

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/334


Өлгий

"Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийн хүрээнд
хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн "л", Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2-ийн 1, Ойн тухай хуулийн 17.2.1 дэх заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2018 оны 05 дугаар сарын 12-нд "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг өргөнөөр татан оролцуулж, мод тарих талбайг сонгон өгч, мэргэжлийн заавар зөвлөгөө өгөн, үр дүнтэй зохион байгуулан ажиллаж, хийсэн ажлын дүн мэдээг 2018 оны 05 дугаар сарын 17-ны дотор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон Сум дундын ойн ангид ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт, дүнг аймгийн хэмжээнд нэгтгэн гаргаж хэвлэл мэдээллийн хэрэгслээр суртчилах ажлыг зохион байгуулахыг Сум дундын ойн ангид тус тус үүрэг болгосугай.



00000790